



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 340

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2020 оны эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн баримтын шалгалтаар нийт 3.6 сая төгрөгийн зөрчил, дутагдал илрүүлснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2020 оны үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал /Л.Насанцэнгэл/-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, дотоод хяналтыг сайжруулж дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 159 дүгээр тогтоолоор Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн балансад бүртгэлтэй, нийслэлийн Баянзүрх дүүргийн 9 дүгээр хороонд байрлах төвлөрсөн дулаан болон цэвэр, бохир усны шугамд холбогдоогүй 30 айлын 6 орон сууцыг сууц эзэмшигчдэд нь үнэ төлбөргүйгээр хувьчлагдсан байрнуудын доорх эдэлбэр газрыг Сууц өмчлөгчдийн холбоонд нь шилжүүлж, эдэлбэр газрын төлбөрийг хариуцуулах;

2.2. Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай 2020 оны 49 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах;

2.3. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөө гарган, биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн Хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ,
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2021 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн
340 дугаар тогтоолын хавсралт



Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал,
түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /сая төгрөг/	Зөрчигдсэн эрх зүйн акт	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяа Эрүүл мэндийн хүрээлэнд зөвшөөрөлгүй ашиглуулсан 117.25 м2 төрийн өмчийн талбайн ашиглалтын зардал	Ерөнхий захирал Л.Насанцэнгэл, Ерөнхий нягтлан бодогч Ц.Хэрлэнцэцэг	3.6	-Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг; -Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам"; -Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай" 49 дүгээр тогтоол	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их сургуулийн харьяа Эрүүл мэндийн хүрээлэнтэй ашиглалтын гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах.
Нийт дүн			3.6		